

“МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, ӨРИЙН УДИРДЛАГА” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2015.11.05-ны өдөр.

ННФ-ын хурлын танхим.

Нээлттэй нийгэм форумын Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын 2016 оны төсвийн өнөөдрийн хэлэлцүүлэг эхэлж байна. Засгийн газраас улсын төсвийн өргөн барьсантай холбогдуулаад ННФ-аас жил бүр улсын төсвийн хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байгаа. Өнөөдрийн хэлэлцүүлэг нь төсвийн тэнцэл, өрийн асуудлаар ярилцана. Ингээд хэлэлцүүлгийг нээнэ үү хэмээн ННФ-ын удирдах зөвлөлийн гишүүн Ж.Үнэнбат таныг урьж байна.

ННФ-ын удирдах зөвлөлийн гишүүн Ж.Үнэнбат: Сайн байцгаана уу. Манай форумын зүгээс жил бүр улсын төсвийн хэлэлцүүлгийг ТББ-ууд, иргэний нийгмийнхэн, судлаачид, эдийн засагчид, хувь хүмүүс болон Сангийн яам, Монгол банкны холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулж ирсэн. Ингэхдээ улсын төсвийн хэлэлцүүлгийн үед УИХ-д хэлэлцэхээс өмнө тусгах саналууд юу байна, шийдвэрт нөлөөлөх зорилгоор зохион байгуулж байгаа. Бид бүгд татвар төлөгч. Татварын мөнгийг хааш нь зарцуулж байгааг мэдэх эрх бидэнд байдаг. Миний мэдэхийн Монгол улс зах зээлд шилжсэнээс хойш жил бүрийн төсөв алдагдалтай төлөвлөгдсөөр ирсэн. Алдагдлыг хаа нэг газраас санхүүжүүлж таарна. Тэр нь өр болж байдаг. Төсвийн өрийн удирдлагын байдал, өрийн хэлбэрүүд олширч байна. Засгийн газар зээл авдаг, зах зээлд бонд гаргадаг, хувийн байгууллагад Засгийн газрын баталгаа гаргадаг. Энэ талаар яригдах байх гэж бодож байна. Энэ хэлэлцүүлэгт та бүхнийг идэвхитэй оролцоорой гэж уриалж байна. 2010 оноос эдийн засгийн өсөлт гарсан. \Уул уурхай, түүхий эдийн үнийн өсөлтөөс\ Гэвч үүнийгээ замбараагүй зарсан. Энэ жил сонгуулийн жил. Бид жилийн зардлаа хэмнээд, хүнээ цөөлөөд, эдийн засгаа хүмиж ажиллах хэрэгтэй байх.

Д.Оюунбадам: Хөтөлбөрийн дагуу Сангийн яамнаас өрийн удирдлага ямар байгаа талаар танилцуулга хийнэ.

Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ё.Амарбат: Энэхүү арга хэмжээг зохион байгуулж байгаа ННФ-ынханд талархал илэрхийлж байна.

“Улсын өр ба Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ” (илтгэл) сэдвээр танилцуулга хийлээ.

Танилцуулгын агуулга:

1. Өрийн удирдлагын хууль, эрх зүйн орчин
2. Улсын гадаад өр болон Засгийн газрын өрийн
3. Дунд хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй өрийн удирдлагын бодлого, зохицуулалт

Өрийн удирдлагын хууль 2015.02.18-ны өдөр батлагдсан. Хуульд:

- Өрийн бүтэц, тооцоолол
- Шинэ нэр томъёонууд
- Тухайн төсвийн жилд хийх зээлээс гаргах өрийн баталгааны дээд хэмжээ
- Өр үүсгэх зориулалт
- Засгийн газрын өийн баталгаа
- Гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулах

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. \2010\ 2015.1.20-нд нэмэлт өөрчлөлт орсон байгаа. \ДНБ-д эзлэх өрийн хэмжээ 2015 онд 58.3, 2016 онд 55.0, 2017 онд 50.0, 2018 онд 40.0 хувь\

Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг боловсруулж, УИХ-ын 2015 оны 51 дүгээр тогтоолоор батлуулсан.

Өрийн удирдлагын асуудалд холбогдох журам, аргачлалууд \8 журам, аргачлалыг шинээр батлуулж хэрэгжүүлж эхлээд байна\

Улсын нийт гадаад өр 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 21,7 тэрбум ам.доллар.

“Монгол Улсын 2016 оны төсвийн өрийн удирдлага” (илтгэл) - судлаач Д.Баярмаа танилцуулга хийлээ.

Д.Баярмаа: Тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтсан.

- Макро эдийн засгийн тэнцвэр ба нэгдсэн төсөв
 - Засгийн газрын өрийн тойм
 - 2016 оны төсөвт тулгарч болзошгүй эрсдэл
 - Нэгдсэн тойм дүгнэлт
- Төсвийн орлогыг Монгол Улсын эдийн засгийн идэвх сэргэх таамаглалд тулгуурлан төлөвлөжээ. Уул уурхайн салбарын орлогын төлөвлөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад илүү бодитой болсон ч дэлхийн улс орнууд болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, дэлхийн түүхий эдийн зах зээлийн ирээдүйн төлөв байдал тодорхойгүй байгаа нөхцөлд төсвийн орлого бүрдэлтэд эрсдэл учирч болзошгүй байна.
- Бүтцийн өөрчлөлт хийх замаар цалин хөлс, НДШ-ийн зардлыг бууруулна. Зээлийн үйлчилгээний төлбөр, татаасын хэмжээ өснө. Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурах ба өмнөх онуудад эхэлсэн он дамжсан төслүүдэд дийлэнх хувь зарцуулагдана.
- Нэгдсэн төсвийн алдагдал өндөр хэвээр байна.
- Төсвийн он дараалсан алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь Засгийн газрын өрийн дарамтыг нэмэгдүүлсэн. Өрийг дахин санхүүжүүлэх, санхүүжилтийн нөхцлийг өөрчлөх нь өртөг өндөртэй. Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд муудаж, зээлжих зэрэглэл дахин буурсан.

Дээрх дүгнэлтэд үндэслэн төсвийн төлөвлөлтийг сайжруулах талаар дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- 2016 оны эдийн засгийн нөхцөл байдлын таамаглалыг харгалзан төсвийн орлогыг бодитой төлөвлөх.
- Төсвийн зарцуулалтын үр ашиг, ил тод байдалд өндөр шаардлага тавих.
- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх болон гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг сайжруулах;
- 2016 оны төсвийн алдагдлыг бууруулах. Төсөвт тавих хяналтыг эрс нэмэгдүүлэх, баталсан түвшнээс илүү алдагдал бий болгохгүй байх. Төсвийн алдагдлыг баталсан түвшнээс хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байх.

“Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад хийсэн судалгаа (илтгэл) - Ж.Сайнзаяа \Үнэн хатамж ТББ\ танилцуулга хийлээ.

Ж.Сайнзаяа: Судалгааг 2015.10.15-11.05-ны хооронд хийсэн. 2010-2016 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хамруулсан болно.

Судалгааны зорилго Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт хэр бодитой байдаг, түүнийг ямар байдлаар баталдагийг судалж, үр дүнг бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэмд танилцуулахад оршино.

2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний өргөн барьсан болон батлагдсан жагсаалтыг харьцуулж үзэхэд ЗГ-аас өргөн барьсан төсвийн төслийн 93 үнэ зөрүүтэй болон төсөвт өртгөөр бүтнээр нь ахиулан баталсан. Засгийн газраас өргөн барьсан төсвийн саналд үнийн дүнг нь тэгээр оруулсан 46 төслийг үнэлэн оруулж баталсан. 1828,7 сая төгрөгийн 3 төсөл ЗГ-аас өргөн бариагүй байхад УИХ-аас шинээр оруулж баталсан.

2011 оны төсөвт ерөнхий сайдын багцад 3174 сая төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад 8164,3 сая төгрөгийн төсөл Засгийн газраас өргөн бариагүй байхад УИХ-аас нэмж баталсан байна. 2012 онд ЗГ-аас өргөн барьсан нэлээд олон төслийн зардлыг УИХ шууд 50 хувиар бууруулж баталжээ.

2013 онд нийт үнэ болон нэрийн зөрүүтэй 2500 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, ЗГ-аас өргөн барьсан төсөл арга хэмжээний жагсаалтад ороогүй 76264,5 сая төгрөгийн 45 төсөл арга хэмжээ УИХ-аар батлагдсан байна.

2014 онд хөрөнгө оруулалтын арга хэмжээний ЗГ-аас өргөн барьсан 17 төсөл нэр буюу 94513 сая төгрөгийн үнийн зөрүүтэй УИХ-аар батлагдсан бол 259307,7 сая төгрөгийн 131 төсөл арга хэмжээ өргөн барьсан жагсаалтад огт байгаагүй.

2010-2016 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг УИХ-аар баталсан байдлыг харьцуулан судлахад доорх байдал ажиглагдлаа.

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр ЗГ-аас өргөн барьсан төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт болон УИХ-аар баталсан жагсаалт нь өөрчлөлт ихтэй байна.
- Хөрөнгө оруулалтыг салбаруудаар авч үзвэл өөрчлөлт ихтэй, зарим жилүүдэд зарим салбар орхигдсон мэт байх байдал ажиглагдаж байна.
- Зарим жилүүдэд жагсаалтад байгаа төслүүдэд 20%, 30%, 40%-ийг жил дараалан цувуулан баталсан нь эдийн засгийн хувьд ихээхэн алдагдалтай, он дамжсан дуусдаггүй барилгууд бий болох үндэс суурь болсон байх магадлалтай.

Бид зардлаа хянаж болж байна, ямар нөөц боломж байна түүнийгээ ашиглах, зарлага зардлаа багасгах боломж бидэнд шинээр гарч байна. 2016 оны хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлт дээр харагдаж байгаа зарим нэг зүйлийг хэлье гэж бодож байна. Уржигдрийн хэлэлцүүлэг дээр соёлын төв бариад байна гэж байсан. 2016-2017 онд 5 соёлын төв шинээр барихаар орж ирж байна. Энд нийт 11 тэрбум төгрөг төсөвлөснөөс 7,6 тэрбум төгрөг нь 2016 онд улсын төсвөөс гаргахаар байгаа. Өөр цаана нь онд дамжсан 10 соёлын төв хүлээж байна. Үүнд 19 тэрбум төгрөг төсөвлөснөөс ирэх онд 4,6 тэрбум төгрөг төсөвлөж байх жишээтэй Ингээд 2016-2017 онд улсын хэмжээнд 16 соёлын төв ашиглалтад орох нь. Ер нь энэ төсөв дээр ойлгомжгүй юм их байна. Жишээ нь Архангай аймгийн Эрдэнэбулган суманд нийтийн номын санг 500 сая төгрөгөөр барина гэж 2011 онд төлөвлөөд, 2012 онд мөн суманд хүүхдийн номын сан барина гэж 585 сая төгрөг төсөвлөсөн байгаа юм. Энэ барилгын ажил хоёулаа дуусаагүй, ирэх онд хоёр номын санд түс бүр 142 сая төгрөг төсөвлөсөн байна. Ингээд Эрдэнэбулган суманд 2 номын сан ашиглалтад орох нь ээ. Мөн Ховдын төв талбайн шинэчлэлийн ажил 2012-2016 онд, нэг талбайн шинэчлэлийн ажлыг 4 жил дамнуулан хийж болох уу. Тэгээд түүнд 1 тэрбум 200 сая төгрөг зарцуулахаар байгаагаас энэ онд 300 сая төсөвлөсөн байгаа юм. Мөн Ховд аймгийн Жаргалант суманд төрийн далбааны өндөрлөг байгуулахаар 200 сая төгрөг 2016 онд төсөвлөсөн байгаа. Энэ суманд энэ жил маш олон сонин сонин хөрөнгө оруулалт төсөвлөгдсөн байна. Орхон аймгийн Баян-Өндөр суманд угтах хаалганы засвар гээд 292 сая төгрөг төсөвлөжээ. Зөвхөн нэг хаалганы засварт бараг 300 аад сая төгрөг зарцуулах нь өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй үед бидний хэмнэлтийн горимд таарч байна уу.

Мөн Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын багцад Батсүмбэрийн ахмадын асрамжийн газар гэж байдаг. Нөхөн сэргээх сувиллын төв барихад 2014 онд 5 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Батсүмбэрийн ахмадын асрамжийн газрын өргөтгөлд 3 тэрбум төгрөг төсөвлөсөн. Нэг дор байгаа нэг зориулалтын барилгад бараг 9 тэрбум төгрөг төсөвлөсөн байх жишээтэй.

Зарим жилд зарим салбар хаягдаад байх юм, зарим жилд зарим салбарт хөрөнгө оруулалт цутгаад байх гэх мэт харьцангуй жишээнүүд олон байна. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт маш их хөрөнгө оруулалт хийгдэж байгаа боловч үрсгал зардал маш ихээр нэмэгдэж байна.

Тэгээд төсвийнхөө хөрөнгө оруулалтыг үр ашигтай, зөв өргөн барьж, гүйцэтгэл нь өргөн барьсан төсөлтэйгээ таарч, дунд нь бага тодотгол хийж байвал зүгээр гэж бодож байна.

Д.Оюунбадам: За баярлалаа. Та бүхэн одоо сонирхсон асуултаа тавьж, өөрсдийнхөө санал бодлыг илэрхийлнэ үү.

Асуулт хариулт.

Байгаль орчин, нөхөрлөлүүдийн холбоо Цэнгэлсайхан: Сангийн яамны төлөөллөөс асуух асуулт байна.

- Хятадын ЗГ-аас 1 тэрбум ам долларын зээл авахаар болж байгаа. Задаргааг харахаар Эгийн голын УЦС-д 827 сая доллар, Эрдэнэтийн дулааны станцад 55 сая доллар, Налайхын зам барихад 48 сая доллар зарцуулна гэж байна. Өнгөрсөн хавар ЗГ-ын хуралдаанаар Эгийн голын УЦС-д 302 сая доллар зарцуулахаар шийдвэрлэсэн. Одоо 827 сая доллар зарцуулахаар болж байна. Энэ ямар учиртай вэ.
- 1 тэрбум долларын зээл маань улсын өрөнд тооцогдож явах уу.
- Азийн хөгжлийн банкнаас 150 сая ам долларын зээл авч байгаа. Энэ юунд зарцуулагдах вэ.
- Хөгжлийн банкны бонд гарч байгаа. Энэ нь орон сууцны урьдчилгаанд зарцуулагдах гэж байгаа тухай ярьж байна. Энэ үнэн үү.
- Тогтворжуулалтын сан гэж илтгэл дээр сая дурдагдлаа. Энэ асуудал Баярцогт сайдын үед л яригдаж байсан. Энэ хэзээ, хэрхэн, яаж байгуулагдах гэж байгаа вэ.
- Дахин санхүүжүүлэх гэж сая илтгэл дээр гарсан. Одоо бонд босгоод урдах бондуудын төлбөрийг төлнө гэж ойлгоод байгаа. Дахин зээл аваад урдах зээлийхээ өрийг төлнө гэсэн үг үү.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Эхний асуулт дээр нарийн албан ёсны хариултыг Эрчим хүчний яам өгөх байх. Хүчин чадал болон анх төсөвлөж байснаас зураг төсөл дээр нь протоколын хэмжээний өөрчлөлт орсон гэж ойлгож байна.

Дараагийн асуултын хувьд 1 тэрбум долларын зээл Засгийн газрын өр. Тогтвортой байдлын тухай хуулинд заасан байгаа. Эрчим хүчинд зарцуулснаас бусад мөнгө нь Засгийн газрын өрөнд тооцогдоод явна.

3 дахь асуултын хувьд Азийн хөгжлийн банкны зээл батлагдаагүй, хэлэлцээрийн шатанд явж байгаа.

4 дэх асуулт Хөгжлийн банкны бондын хувьд Хөгжлийн банкнаас тодруулах нь зүйтэй.

5 дахь асуултын хувьд тогтворжуулалтын сан биш эргэн төлөлтийн сан гэж хэлэх байх. Бид том хэмжээний зээлүүд дээр төлбөрт нь зориулаад сан үүсгээд зээлийг төлөх тухай ярьж байсан. Харамсалтай нь энэ маань хэлэлцүүлгийн шатанд хасагдсан. Ер нь өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн хүрээнд энэ сан зайлшгүй байх ёстой гэсэн санал гараад явж байгаа.

Дахин санхүүжилтийн асуудал хөндөж байна. Одоогийн байдлаар гаргасан байгаа Чингис бондын 1,5 тэрбум, баталгаа гаргасан өр гэх мэтчилэн өрүүдийг яг одоогийн эдийн засгийн нөхцөл байдлаар шууд төлөх боломж байхгүй байгаа. Стратегийн баримт бичигт заасны дагуу зохицуулалтын арга хэмжээ аваад хугацаанаас өмнө төлөх, зардлыг бууруулах, 1 жилд ирэх ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авна.

Монгол банкны валют, эдийн засгийн газрын эдийн засагч Мөнхзул: Өрийг өнөөгийн үнэ цэнээр тооцоход ашиглагддаг дискаунт рэйтийг хэд гэж тооцож байгаа вэ.

Хэлэлцүүлэгт оролцогч: Сангийн яам, Монгол банк буюу сангийн болон мөнгөний бодлого барьж байдаг 2 байгууллага эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого явуулах нь зүйтэй гэсэн саналууд гардаг. ОУВС, Дэлхийн банк зэрэг байгууллагуудаас ирсэн зөвлөхүүд, дотоодын эдийн засагчид ч тэгж зөвлөдөг. Яг явуулж байгаа бодлого нь бодлого, гүйцэтгэлийг нь харахаар ихэвчлэн мөчлөг дагасан бодлого явуулаад байдаг. Энэ талаар Сангийн яамнаас эрх зүйн зохицуулалт хийхээр төлөвлөж байгаа зүйл байна уу. З дахь асуулт. Өрийн дахин санхүүжилт хийнэ гэж сая ярилаа. Богино хугацаанд угаасаа Засгийн газрын өрүүдийг, зээлүүдийг санхүүжүүлэх боломж байхгүй. Харин урт хугацаандаа юу гэж харж байгаа вэ.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Эхний асуулт нь дискаунт рэйтийг хэрхэн тооцсон бэ гэж байна. Ангиллаас нь харах юм бол Засгийн газрын өр маань дотроо хэд хэдэн ангиллаас бүрдэж байгаа. Тухайлбал: Засгийн газрын гадаад зээл дээр ОУВС-аас гаргасан аргачлалын дагуу 5 хувиар тооцсон, ЗГ-ын гадаад үнэт цаасны хувьд ОУВС, Дэлхийн банкнаас тогтоохдоо дэлхийн эрсдэлгүй түвшинд тооцогдож байгаа АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны үнэ дээр тухайн орны өөрийнх нь эрсдийн нэмэгдлийг нэмээд тооцдог, дотоод үнэт цаасны хөнгөлөлтийн хувьд Монгол банкны бодлогын хүүгийн түвшингээр тооцсон байгаа.

Хоёр дахь асуултын хувьд оновчтой тайлбар өгч чадахгүй нь. Энэ дээр төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас хариулт өгөх байх. Манай өрийн удирдлагын хэлтсийн хамаарах асуудал биш.

Гурав дахь асуултын хувьд дунд хугацаанд дахин санхүүжилт хийх, эргэн төлөлтийн сан байгуулж төлөх тухай ярьсан. Гаднаас авах зээл, тусламжийг эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх замаар эргэн төлөлтийг хийнэ гэж тусгасан.

Байгаль орчин, иргэний зөвлөл Оюунчимэг: Миний хувьд мэргэжлийн хүн биш болохоор цаасан дээрх тооны талаар яримааргүй байна. Улсын өрийг ТББ-үүд бид өнгөрсөн жил мөн үед хэлэлцсэн. Хуулиараа болохоор ДНБ-ний 40 хувиас хэтрэхгүй байдаг гэж хэлчихээд Сангийн яам нь 50 хувь болгоно гээд ингэж хэтэрч болдог юм уу. Үүнийгээ УИХ-д дээр яриад бүр 50 байтугай 55 хувьд хүргэнэ гээд өөрсдөдөө зориулж хуулиа хүртэл өөрчлөө биздээ. Тэгээд өнөөдрийн хувьд Монгол улс хүнд үйлдвэрч үгүй, хөнгөн үйлдвэр ч үгүй болсон. Зөвхөн гадаадаас зээлсэн мөнгөөрөө амьдраад байдаг. Дахин зээл авах тухай, гүйлгэ гүйх тухай л яриад биднийгээ өрөнд хийгээд байнаа. Зүгээр 10 хүүхэдтэй өрх толгойлсон эх орон гэрээ аваад яваад байна. Улс орны толгойд гарчихаад 3 сая иргэнээ аваад явж чадахгүй байна. Төрийн байгууллагын албан тушаалтнуудын цалинг 30 хувь, 10 хувь буулгана гэхэд эсэргүүцээр байгаад болилоо. Тэгэхэд цаана чинь ямарч орлогогүй, амьдрал ядуу олон өрх байсаар байна. Манай Монгол Улс хүний эрхийн олон улсын байгууллагын гишүүн орон. Монгол улсын төр, засаг, шийдвэр гаргах түвшинд байгаа эрх мэдэлтнүүд ард түмнээрээ дэндүү тоглож байна. 1.5 сая км² нутагтай, дэлхийд тэргүүлэх хэмжээний баялагтай, 3-хан сая хүн амтай, 60 сая малтай ийм улс орныг аваад явчих чадал энэ төр засагт байна уу. Сүүлийн 25 жилд ард түмний амьдралыг сайжруулах тухай ярьсаар, амьдрал улам доройтсоор байна. Өнөөдөр төв цэвэрлэх байгууламжийг 312 сая доллараар засварлана гээд яриад байна. Монгол инженерүүд, эрдэмтэд 100 саяар тэр байгууламжийг засварлаад ажиллуулах боломжтой гээд байна. яагаад монгол инженерүүддээ итгэхгүй, заавал Француудаар үнэтэй хийлгэх гээд байгаа юм. Монголын иргэдийн оюун ухаанд итгэх хэрэгтэй байна.

Удирдлагын академи Л.Отгонтуяа: Сангийн яамны мэргэжилтнүүдээс асууя. Түрүүн хэлсэн эргэн төлөгдөх чадвартай төсөл арга хэмжээнд дахин санхүүжилт хийх

өөрөөр хэлбэл өрөө төлөх хөрөнгө оруулалтыг зарцуулна гэж. Үүнийг ямар бодлогын баримт бичигт, ямар хөтөлбөр, стратегийн ямар баримт бичигт тулгуурлаж гарах вэ. Зөвхөн эдийн засагтаа хэрэгтэй, эргэж үр ашгаа өгөх төслүүдэд бизнесийн салбартаа хийх хөрөнгө оруулалт байх юм уу, эсвэл улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан тэр ажлуудыг санхүүжүүлэхэд зориулагдах юм уу. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр гэж зүйл өнөөдөр Сангийн яаманд байна уу, энэ нь өрийн удирдлагын үйл ажиллагаатайгаа хэрхэн холбогдож байна вэ.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Эдийн засгийн үр ашигтай төслүүдэд зарцуулна гэдэг маань өрийн удирдлагын хуулиар зохицуулагдаж байгаа. Өрийн удирдлагын хуулиндаа улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээг санхүүжүүлнэ гэж заасан. Сангийн яамны зүгээс УИХ-ын Тамгын газраас урт хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулж байгаа. Энэнтэйгээ нийцүүлэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулаад дагалдуулна. Урт хугацааны хөгжлийн хөтөлбөр маань нэлээн урт хугацаагаар төлөвлөөд, түүнийгээ богино, дунд хугацаагаар батлаад, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдээ ялангуяа Засгийн газрын гадаад зээл, гадаад үнэт цаасны хөрөнгөөр эдийн засгийн үр дүнтэй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлнэ гэж заасан. Улсын хуваарьт бол нийгмийн ач холбогдолтой төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх эрх нь байгаа.

Удирдлагын академи Л.Отгонтуяа: Гэхдээ энэ бол бидний хүсэл, мөрөөдөл юм. Бодит амьдрал дээрээ хэрэгжүүлдэггүй. Бид энийг тунхаглал байдлаар яваад баймааргүй байна. Би бас 2 илтгэгчдээ баярлалаа гэдгээ хэлье. Баярмаа ч, Сайнзаяа ч тэр өнгөрсөн жил яг энэ асуудлаа судалж байсан учир энэ жилийн судалгаа баримт маш сайжирч гарч байгааг харж байна. Ялангуяа Сайнзаяагийн хийсэн судалгаан дээр тулгуурлаж хэдэн санал хэлье. Түрүүн слайд дээр гарсан 2010-2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ гээд өргөн барьсан, баталсан, тодотгол, гүйцэтгэл гэдэг дээр 2012 онд 149 тэрбум төгрөгийг ЗГ-аас УИХ-д өргөн барьсан байхад 1,7 их наяд төгрөг болоод батлагдсан байгаа. Харин 2013 онд харьцангуй гайгүй, 2014 онд 1,4 их наяд нь 1,7 их наяд болсон, 2015 онд 993 тэрбум төгрөг 1,5 их наяд болоод батлагдсан байгаа нь УИХ нь төсөвт үнэмлэхүй эрх мэдэл эдэлж байгааг нотолж байна. Засаглалын эрх мэдлийн хуваарилалтаар бол УИХ хууль тогтоодог, ЗГ хэрэгжүүлдэг, шүүх нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг системтэй. Үндсэн хуулинд үүнийгээ хуульчилсан мөртлөө эрх мэдлийн систем алдагдсаныг харуулж байна. Манай улсын парламентаас өөр ямар ч парламент ЗГ-аас өргөн барьсан төслийг өөрчилж баталдаг улс орон хаана ч байхгүй. Ялангуяа үндсэн хуулиндаа тов тодорхой заагаад өгчихсөн үед. УИХ бол ЗГ-ынхаа өргөн барьсан төслийг батлаад хянаж байх үүрэгтэй. Дээр нь Сангийн яамны газар хэлтсүүд хоорондоо маш уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй. Тэр мэднэ, энэ мэднэ гээд орхихоор энэ Монгол улсын төрийн байгууллагууд яаж уялдаж ажиллах вэ. Хөрөнгө оруулалтын явц, үр дүнгийн хяналтыг сайжруулах ёстой. Түүний гол суурь нь мэдээлэл байх ёстой юм.

Ховдын төв талбайн тохижилтын ажил байна. 2 жилийн өмнө тохижуулсан талбай дахин дахин хөрөнгө оруулалт шаардаад. Магадгүй улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийгдээд, дахин орон нутгийн хөгжлийн сангаас ч хөрөнгө оруулалт оруулсан байхыг үгүйсгэхгүй. Энэ мэтчилэн 2 эх сурвалжаас хөрөнгө оруулалт орсон байж ч магадгүй. Энэ бүхэнд маш хяналттай байх шаардлагатай.

Ил тод байдал сан Бямбасүрэн: Сангийн яам Хөгжлийн банктай ямар харилцаатай байдаг вэ. Хяналт шалгалтын болон санхүүжилтийн асуудлаар.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Хөгжлийн банктай олон талын уялдаа холбоотой ажилладаг. Хөгжлийн банк өөрөө тусдаа хуультай. Хуулиараа үйл ажиллагаа нь зохицуулагддаг. Хөгжлийн банкнаас гаргасан үнэт цаасны баталгаан дээр хамтран ажилладаг. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн чиглэлээр болон шинээр зээллэг гаргахад санал дүгнэлтээ өгдөг.

Байгаль орчин, нөхөрлөлүүдийн холбоо Цэнгэлсайхан: Хөрөнгө оруулалт, өр зээлийн асуудлаар Сангийн яамнаас гадна хариуцлага хүлээх бас нэг байгууллага бол Монгол банк юм. Үнэндээ Монгол банк бол ажиллаж чадахгүй байна. Монгол банкны төлөөлж хэдэн хүн ирсэн байна. Асуулт байна. Арилжааны банкны зээлийн хүүний талаар УИХ-аар мөнгөний бодлого хэлэлцэж байхад яригдаж байсан. Их хурлын гишүүд арилжааны банкны хүүг хэдэн хувиар буулгах вэ гэхэд Монгол банкны ерөнхийлөгч Золжаргал хариулж чадахгүй байсан. Механикаар шууд буулгаж болохгүй гэсэн юм л ярьж байналээ. Ирэх жилийн төсөвт зээлийн хүүг хэдэн хувиар буулгахаар тооцож байгаа вэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

Монгол банкны мөнгөний бодлого, судалгааны газар Цэнд-Аюуш: Зээлийн хүүг хэдэн хувиар буулгах вэ гэдэг нь макро эдийн засагтайгаа уялдсан зүйл байдаг. Төгрөгийн зээлийн хүү ярихаас өмнө эхлээд гадаад зах зээлийн хүүний тухайд ярина. Хувь хүн дээр төгрөгөөр хадгаламж хийх үү, валютаар хадгаламж хийх үү гэдэг дээр зээлийн хүүг бууруулахад ямар дарамт үзүүлдэг гэхээр хадгаламжийн хүүг бууруулах сонголт болчихдог байгаа. Хадгаламжийн хүү буурах нь төгрөгийн өгөөжийг бууруулдаг. Долларын ханш төгрөгийн эсрэг чангараад байгаа үед төгрөгийн өгөөжийг бууруулаад ирэхээр доллар орж ирэх урсгал нь улам л буурдаг. Монголд доллараа байршуулах сонирхол багасдаг. Иймээс зээлийн хүүг шууд 5 юмуу 1 хувь гэж бууруулах ямарч боломжгүй нөхцөлд байна. Нөгөө талаасаа зээлийн хүүг тогтоогч байгууллага нь арилжааны банкууд юм. Төв банкны зүгээс мөнгөний бодлогын сувгуудаараа дамжуулж арилжааны банкинд нөлөөлдөг. Арилжааны банк эдийн засгийн хямралын үед өөрөө өндөр эрсдэлд орсон байдаг. Эдийн засаг хүндэрсэн үед зээлийн хүүг бууруулах нь өндөр эрсдэл үүсгэнэ. Банкин дээр очоод харахад эрсдэлтэй зээл маш ихээр нэмэгдсэн байдаг. Тэр нь уг банкны зардал болдог. Зардалаа яаж төлөх вэ гэхээр хадгаламжийн хүү болон зээлийн хүүний зөрүүнээс олсон ашгаараа нөхдөг. Тэгэхээр зээлийн хүүг шууд тэдэн хувиар буулгана гэдэг онолын хувьд ч, практикийн хувьд ч ямарч боломжгүй юм.

Байгаль орчин, иргэний зөвлөл Оюунчимэг: Сүүлийн үед эдийн засаг хүндэрсэн гээд концессоор хийнэ гээд байгаа. Төмөр зам барина г.м Концесс гэдэг юм чинь Монголын өрөнд байдаг уу. Тэрийгээ яаж төлнө гэж тооцоолдог юм.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Концесс нь өөрийн гэсэн хуультай байгаа. Концесс нь хэд хэдэн хэлбэртэй. Барих, ашиглах, шилжүүлэх. Өмнө нь хөрөнгө оруулалт байхгүй үед концессоор шийднэ гэдэг асуудал их байсан. Хувийн хөрөнгөөр барьчихаад шилжүүлэх үед энэ нь өрд орно гэж тооцож байгаа.

Удирдлагын академи Л.Отгонтуяа: Нийслэлийн концессыг нэгдсэн төсвийн өрөнд оруулдаг уу.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Нийслэлийн концесс Засгийн газрын өрөнд ордоггүй.

Оюунчимэг: Уржигдрын хэлэлцүүлэг дээр танай яамны мэргэжилтэн Мөнхзул гэдэг хүн Нийслэлийн хөрөнгө оруулалт Сангийн яаман дээр хянагддаггүй гээд байсан. Үнэн үү.

Сангийн яамны төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Мөнхгэрэл: Нийслэлтэй холбоотой нэг л жишээ хэлбэр. Сангийн сайдтай бүх аймгийн засаг дарга нар тухайн төсвийн жилд гэрээ байгуулдаг. Нийслэл бол ганцаараа гэрээ огт байгуулахгүй л байдаг. Ингээд л хэлчихэд аль ч утгаар нь хариулт болно. Гэхдээ 2014 онд ЗГХЭГ дээр аймаг, нийслэлийн засаг даргатай гэрээ байгуулсныг үнэлэхэд Нийслэл 2 дугаар байранд орсон байна лээ. Тэгэхээр бусад үзүүлэлтээрээ өндөр л байсан юм байлгүй дээ. Орлоготой холбоотой Улаанбаатар хотын татварын асуудал гээд зөндөө олон юмыг та бүхэн өргөн хүрээтэй харж байгаа байх. Би өөрөө улсын төсвийн хөрөнгө оруулалттай их холбоотой ажилладаг хүний хувьд Сайнзаяатай санал солилцоё гэж бодож байна. Ялангуяа зөвлөмж гэсэн хэсэг дээр 2016 оны төсвийн төлөвлөлттэй холбоотой тодорхой үр дүнд хүргэх чин эрмэлзэлтэй байгаа юм байна гэж би харж байна. Зөвлөмж дээр төсөлд шаардагдах зардлыг цаг хугацаанд нь бүрэн санхүүжүүлэх нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг дээшлүүлэхэд ач холбогдолтой гэдэг өгүүлбэр бүхэлдээ агуулгын хувьд найруулагдах учиртай гэж үзэж байна. Ямар утгаар гэхээр гүйцэтгэл хийгдээгүй байхад санхүүжүүлэх асуудал бас яваад л байгаа. Бүрэн санхүүжүүлэх гэдэг утгаар биш, ер нь хийгдсэн ажлын гүйцэтгэлийг л санхүүжүүлэх ёстой шүү гэдэг утгаар залруулж өгөөчээ гэж хүсч байна. Нөгөөтэйгүүр УИХ-д өргөн баригдахаараа асар их хэмжээгээр нэмэгддэг гэдэг асуудал гишүүдийн тойрогтоо зарцуулдаг мөнгөтэй холбоотой. Энэ мөнгө аль ч засгийн үед үргэлжилсээр байгаа асар том зарчмын үхралт байсан гэдгийг дүгнэлтдээ оруулж өгөөсэй гэж бодож байна. Тэгж оруулахдаа цаад хамгийн ноцтой үр дагавар нь барилгын тухай хуулийг зөрчдөг асуудал юм. ТЭЗҮ байхгүй, зураг төсөвгүй объектыг УИХ дээр оруулдаг. Хортой үр дагавартэй ийм асуудлыг хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгахгүй байх ёстой хуулиа бариачээ гэдгийг зөвлөмж болгож, төсөв хэлэлцэж байгаа үед оруулж өгвөл форумын үр дүнд хэрэгтэй гэж бодож байна. Уг нь Засгийн газарт УИХ эрх өгөөд, тэр нь маш хатуу хяналттай явдаг боломж өмнө нь байсан юм. Гэтэл одоо тэр бол бүр байхгүй болсон. Энэ хэлэлцүүлэгт анх удаа орж үзэж байна. Та бүхэнд баярлалаа.

Л.Отгонтуяа: Ялангуяа төсөлд шаардагдах зардлыг цаг хугацаанд нь санхүүжүүлэх, Төсвийн хуулиараа тухайн төслийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ гэдэг маш зүйтэй. Гэрээний дагуу цаг хугацаанд нь санхүүжүүлж, тодорхой хяналтын дор гүйцэтгэлийг хянаж байх.

Цэнгэлсайхан: Монгол улсын эдийн засаг дан ганц уул уурхайгаас хамаарч байна. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар яагаад хөгжихгүй байна. Зээлийн хүү маш өндөр байна. Энэ тал дээр Монгол банк юуч хийхгүй байна. Маш сэтгэлгүй байна. Арилжааны банкны лоббинд орчихсон, шаардлага тавьж чаддаггүй. Сангийн яамнаас зээлийн хүү бууруулах талаар ямар арга хэмжээ авах вэ.

Сангийн яамны мэргэжилтэн Ё.Амарбат: Хувь хүний зүгээс хариулахад маш олон хүчин зүйл байдаг. Банк байршуулсан хадгаламжийн хүүгээс ашиг олдог байгууллага. Банкуудад хадгаламж эзэмшдэг хүмүүсийн хадгаламжийн хүүг бууруулах хүчин зүйлс юу байж болох вэ гэдэг дээр ажиллавал зүгээр юмүү.

Монгол банк, Цэнд-Аюуш: Банкуудын өрсөлдөөний дүнгээр хүү тогтоогдоно. Эдийн засаг тогтворжих тусам хүү зөв гольдролдоо ордог. Ханш өсөхөөр бодит орлого буурдаг.

Нийт эдийн засгийн хүрээнд аль нь оновчтой сонголт вэ гэдгийг бодлого боловсруулагчдын зүгээс сонгоно.

ННФ, Д.Оюунбадам: Өнөөдрийн хэлэлцүүлгийн ажиллагаа өндөрлөж байна. Бид хэлэлцүүлгийн явцад гарсан санал дүгнэлтийг нэгтгэж, УИХ, ЗГ-т хүргүүлнэ. Та бүхнийг манай хэлэлцүүлэгт идэвхитэй оролцож, үнэтэй санал зөвлөмж өгсөнд баярлалаа.

----- о ----- О ----- о -----